



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/94

Шивээговь сум

Төсөл сонгон шалгаруулалтаар
газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах явуулах журам”-ын 11.10 дахь хэсэг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 06 сарын 14-ний өдрийн “Сумын Газар зохион байгуулалтын 2024 оны тухайн жилийн төлөвлөгөөнд нэмэлтээр газар тусгах тухай” 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн А/89 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтад ялагч болсон 3 (гурав) малчдын хоршоонд хавсралтад заасан газрыг эзэмшүүлсүгэй.

2.Малчдын хоршоонд эзэмшүүлсэн нэгж талбарыг газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд бүртгэж, газар эзэмших эрхийн эд хөрөнгийн улсын бүртгэлд бүртгүүлж, газар эзэмшүүлэх гэрээ, гэрчилгээг цахимаар үүсгэн баталгаажуулахыг Газрын даамал (Т.Өлзийбуд)-д үүрэг болгосугай.

3.Газрыг зориулалтын дагуу ашиглаж, гэрээнд заасан нөхцөл, болзлын хүрээнд газрын төлбөрийг хугацаанд төлөхийг газар эзэмшигч малчдын хоршоодод тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА

D:\My Documents\zaxiramj.doc

42124 241



Сумын засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 08-ний өдрийн 1194 дугаар захирамжийн хавсралт



ХОРШООДОД ЭЗЭМШҮҮЛЭХ ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ, ЗОРИУЛАЛТ, ХУГАЦАА

№	Газар эзэмшигчийн нэр (хоршоо)	Регистрийн дугаар	Төлөвлөлтийн нэгж талбарын дугаар	Эзэмшүүлэх газрын байршил	Хэмжээ м.кв (га)	Зориулалт	Эзэмшүүлэх хугацаа
1	Шивээ сэрүүн сартуул	4618505	4096867	Хогийн цэгийн урд талд	5	Мал эмнэлгийн үйлчилгээний цэг	15 жил
2	Буман тоногт	4618416	4096866	Хогийн цэгийн урд талд	5	Мал аж ахуйн үйлдвэрлэл	15 жил
3	Эрдэнэ толгойн булаг	4612507	4095419	Хөтлийн ухаан хойд талд	5	Эрчимжсэн мал аж ахуйн ферм	15 жил
Нийт					15		

--- оОо ---